



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 12

Эрдэнэт

Хувь хэмжээ тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 44 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид тойрогт ажиллах үйл ажиллагааны зардлын дээд хязгаарыг сар бүр 500,000 төгрөг, Тэргүүлэгчдэд олгох урамшуулалын дээд хязгаарыг сар бүрийн 50,000 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА